



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.12.04 № 01/2572

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулга хүргүүлэх тухай**

Тус компаниас зарласан ЭТТХК/20240102019 дугаартай Автожин /40 метрийн урттай, 250 тонн/ нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын баримт бичигт Монополын эсрэг газарт тендерт оролцохыг сонирхогч этгээдээс гомдол гарсны дагуу тус гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1985 дугаартай “тендерийн баримт бичиг хянасан тухай” албан бичгийг ирүүлсэн.

Тус “тендерийн баримт бичиг хянасан тухай” албан бичигт “Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.1.2-т заасан шалгуур үзүүлэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг дагуу боловсруулсан байна. Иймд тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг үүгээр мэдэгдэж байна.” гэсэн байна.

Иймд Монополын эсрэг газраас ирүүлсэн 01/1985 дугаартай “тендерийн баримт бичиг хянасан тухай” албан бичгийн дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаа, тендерийн нээлт хийх хугацаанд орсон өөрчлөлтийг хүргүүлж байна. Үүнд:

| Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ |   |
|------------------------|---|
| ТШЗ 26.1.              | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:<br>Огноо: 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр<br>Цаг: 09 цаг 00 минут   |
| ТШЗ 26.2.              | Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.<br>Огноо: 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр<br>Цаг: 09 цаг 00 минут<br>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: “Эрдэнэс Таван толгой” ХК, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын-8, Финанс төв, 5-р давхар, 504 тоот, Улаанбаатар хот-15160, Монгол Улс |

Дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ

1124044740